



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/394

Есөнбулаг сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.9 дэх заалт, сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал, Онцгой комиссын 2025 оны 7 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Есөнбулаг сумд орсон усархаг борооны улмаас үерийн далан, суваг шуудууг сэргээн засварлах ажлыг гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн техник хэрэгслийг татан оролцуулж шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Цаг уурын байгууллагаас гаргасан мэдээллээр 6, 7, 8 дугаар саруудад гэнэтийн аадар, үер тохиолдох төлөвтэй байгаа тул урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, бэлэн байдлыг хангаж ажиллахыг Ус,цаг уур, орчны шинжилгээний төв (Н.Алтантуяа), Онцгой байдлын газар (хурандаа Ц.Лувсанжамц), гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн нарт үүрэг болгосугай.

3.Дээрх зардалд шаардагдах 15,460,800 төгрөг (арван таван сая дөрвөн зуун жаран мянга найман зуу)-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Алтангэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2018 оны
07 дугаар сарын 04 -ны өдрийн
394 дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Шатахуун	литр	4630	3250	14,994,200
2	Хоол	Ширхэг	31	15,000	466,600
	Нийт	-	-	18,250	15,460,800

__ оОо __